



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2013 оны 264 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Бүртгэл хөтлөх журам” (цаашид “Бүртгэл хөтлөх журам” гэх)-ын Тавдугаар зүйлийн гарчгийн “Тав” гэснийг “Дөрөв” гэж, 5.1, 5.2 дахь хэсгийн дугаарыг “4.1”, “4.2” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Бүртгэл хөтлөх журмын 1.1-ийн “тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх,” гэснийг хассугай.

3. Бүртгэл хөтлөх журмын 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн газар /З.Энхболд/, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс /Ц.Батзул/-т тус тус даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР